ХАНГЫЛ ҮСГИЙН БАЯР 21 ДЭХ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

ГХС-ийн Ази судлалын тэнхимийн Солонгос хэлний баг солонгос хэл судалж буй ШУТИС-ийн оюутнуудад солонгос хэл соёлыг сурталчилж, солонгос хэл сурах хүсэл эрмэлзлэлийг хөгжөөх, оюутнуудын мэдлэг чадварыг сорьж, авьяасыг хөгжүүлэх зорилгоор 2026 оны 10 дугаар сарын 29-нд “Хангыл үсгийн баяр”-ыг 21 дэх жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Уг баярт ГХС-ийн Гадаад хэлний орчуулга /Солонгос хэл/ мэргэжлээр сурч буй оюутнууд болон МХТС, МС, МИТС, НХС, ХХҮДС-ийн 2+2 хөтөлбөр, Ерөнхийлөгчийн илгээлт-2100 хөтөлбөрийн солонгос хэлний бэлтгэл анги, нийт 250 орчим оюутан, зөвлөх багш нарын хамт оролцлоо.

Хангыл үсгийн баярыг ГХС-ийн захирал Ц.Энхбаатар нээж, МХТС-ийн МСАБТ-ийн эрхлэгч Б.Мөнхбаяр, МИТС-ийн ахлах багш Б.Должинсүрэн нар амжилт хүсч үг хэлэв. Хангыл үсгийн баяраар 1-р курсийн оюутнуудын дунд уран илтгэлийн, цэвэр бичгийн, солонгос үлгэрт дуу оруулах тэмцээн, 2-р курсийн оюутнуудын дунд үгийн сан, солонгос үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийх, орчуулгын тэмцээнүүд зохион явуулж, оюутнуудын мэдлэг, ур чадвар, авхаалж самбааг сорив. Мөн бүх оюутныг хамруулан “Хамгийн амттай Кимбаб” тэмцээнийг зохион байгуулж, амттай кимбабны амталгаа хийж, цагийг хөгжилдөн өнгөрүүллээ. Тэмцээнийг КОЙКА байгууллагын сайн дурын ажилтан, 23-р сургуулийн багш Пак Чанбом, КОЙКА байгууллагын сайн дурын ажилтан, ШУТИС-ийн МС-ийн зөвлөх Ким Гёнсү, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны гишүүн, солонгос хэлний мэргэжлийн хөтөч Э.Гэрэлчулуун нар шүүн, тэмцээнийг тэгш шударга зохион байгуулж, дүгнэх зарчим баримталлаа.



Нээлтийн үг: ГХС-ийн захирал Ц.Энхбаатар, профессор багш Н.Мэнд



Оюутнуудын дэвүүрт бүжиг



Шүүгчид



Тэквандогийн үзүүлбэр



I байр Э.Бэрцэцэг /МИТС/
II байр Г.Номинсувд /МИТС/
III байр Г.Нямдэмбэрэл /МХТС/
Тусгай байр: *БС бүрээс 1 оюутан*
Цэвэр бичгийн тэмцээний шагналтнууд



I байр Залуужуулдаг булаг /МХТС/
II байр Улаан малгайт /ГХС/
III байр Хынбү ба Нульбу /МС/
Үлгэрт дуу оруулах тэмцээний шагналт багууд



I байр П.Марал /МХТС/
II байр С.Оюу /МХТС/
III байр Т.Тэнгис /МХТС/
Үгийн сангийн тэмцээний шагналтнууд



I байр Б.Энх-Амгалан /МИТС/

II байр Г.Эрхэм-Амар /МХТС/

III байр Б.Анужин /ГХС ЕИ/

Уран илтгэлийн тэмцээний шагналтнууд



I байр Г.Анужин /ГХС/
II байр Б.Одгэрэл /ГХС/
III байр П.Марал /МХТС/
Орчуулгын тэмцээний шагналтнууд



I байр Цасан гоо жүжиг /МХТС/
II байр Улаан малгайт жүжиг /МХТС/

Жүжгийн тэмцээний шагналт багууд

ГХС-ийн 1, 2 дугаар курсын оюутнууд дэвүүрт бүжиг, цохилуур хөгжмийн тоглолт, МХТС-ийн 1, 2 дугаар курсын оюутнууд тэквандогийн үзүүлбэр, К-Поп дуу, солонгосын уламжлалт цохилуур хөгжмийн тоглолт үзүүлж тэнгийнхэндээ амжилт хүсэв.



Хамгийн амттай кимбаб хийх тэмцээнд шалгарсан ГХС-ийн 1-р курс



МХТС-ийн 2-р курсийн оюутнуудын солонгосын уламжлалт цохилуур хөгжмийн дөрвөл “самулнури” хөгжмийн тоглолт

ГХС-ийн солонгос хэлний багийн багш Н.Мэнд, П.Батцэцэг, Ц.Отгон, Н.Булганчимэг, Д.Анхтуяа, Ү.Жанаргүл нар оролцож оюутнуудаа хөгжөөн дэмжиж, тэднийхээ амжилтаар бахархаж, оюутнаа дэмжин ажиллалаа. Тус баярын үйл ажиллагааг дэмжин тусалсан МХТС-ийн захирал Л.Баяр-Эрдэнэд талархалаа илэрхийлэн, хамт олонд нь ажлын амжилтыг хүсэн ерөөе. Техник аппаратур дээр ажилласан А.Цэрэнхүүдээ баярласнаа илэрхийлье. Оюутнууддаа сурлагын өндөр амжилт хүсч, оюуны мэлмий нь үргэлж тунгалаг байхын ерөөл өргөе.



Хангыл үсгийн баярт оролцсон оюутнууд багш нарын хамт 2026.10.29

Мэдээ бэлдсэн: АСТ-ийн профессор Н.Мэнд
Солонгос хэлний багш Н.Булганчимэг